



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРСЭН БАЙНА**

**2023 оны 04
дүгээр сар**

**АУДИТЫН СЭДЭВ: УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН
2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

2023 он

АГУУЛГА

АГУУЛГА	2
Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товчьег	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
А.ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ НИЙЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТАД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА	8
А.1. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ нь Монгол Улсын урт болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй 54.5-95 хувь уялдсан байна.....	8
А.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 95 хувь нь “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-той нийцсэн байна.....	8
А.1.2. Батлагдсан төсөл арга хэмжээ нь Монгол Улсын 2021-2025, аймгийн 2021-2025 оны үндсэн чиглэлд нийцсэн боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн 63.6 хувь нь тусгагдаагүй байна	9
А.1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 54.5 хувь нь улсын бодлогод, 91.7 хувь нь аймгийн Хөгжлийн төлөвлөгөөнд нийцэж, эерэг өөрчлөлт бий болох нөхцөл бүрэлдсэн байна.....	10
А.2. ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТАД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.....	11
А.2.1. Шинээр хэрэгжих 22 төсөл арга хэмжээ нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой төсөл арга хэмжээ байна.....	11
А.2.2. Аймгийн ТЭЗ-ийн саналд үндэслээгүй 10 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнд оруулж баталсан байна.....	11
А.2.3 Батлагдсан төсөл арга хэмжээний 38.8 хувийн зураг төсөө нь төлөвлөлтийн шатанд бэлэн болоогүй байна.....	12
А.2.4 Барилга байгууламжийн 5 төсөл арга хэмжээний төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар дүгнэлт гараагүй байна.....	13
А.2.5. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн зарим заалтыг мөрдөж ажиллаагүй байна .	13
Б.1. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА	14
Б.1.1. ТЭЗ-даас төсөл, арга хэмжээг хуульд заасан хугацаандаа эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг хугацаанд зарласан боловч төлөвлөсөн хугацааг дунджаар 44 хоногоор хоцроожээ	14
Б.1.2. Тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан байна.....	15
Б.1.3. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна	16
Б.2. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНТЭЙ БАЙНА	17
Б.2.1 Барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэсэн байна.....	17
Б.2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд их засварын ажил тусгагдаагүй байна	20
Б.2.3. Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж нь баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцсэн байна	20
Б.2.4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд ТЭЗҮ ангиалтай төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна.....	21
Б.2.5 Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ байхгүй байна.....	21
Б.3 САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ОЛГОСОН БАЙНА	21
Б.3.1. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.....	21
Б.3.2 Нийт 16 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх хугацааг нэмэлт гэрээгээр сунгасан байна	23
Б.4. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ЗОХИХ ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.....	24
Б.4.1. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагаас хяналтыг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна	24
Б.4.2. Хөрөнгө оруулалтын явцад Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна	25
Б.5. Төсөл арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна	26

Б.5.1. Төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэж, холбогдох хууль, дүрмийн дагуу дүгнэлт гаргаж, хүлээн авсан байна	26
Б.5.2. Зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцож ажилласан байна	26
Б.5.3. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна	27
В.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	28
В.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 18 төсөл арга хэмжээ нь дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна	28
В.1.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна	29
В.2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА	29
В.2.1. Худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна	29
В.2.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 88.9 хувь нь хугацаандаа хэрэгжсэн байна	31
В.2.3 Төсөл арга хэмжээний санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон байна	31
В.2.4. Хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавиагүй байна	33
В.2.5. Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна	33
ДҮГНЭЛТ:	35
5. Тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна	35
8. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагаас хяналтыг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна	35
ЗӨВЛӨМЖ:	36
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	37

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
СС	Соёлын сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийг хамгаалах сайд
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгө үйлдвэрийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	ТЕЗ-даас эрх шилжүүлсэн ТАХ-ний нэгдсэн судалгаа	15
Хүснэгт 2	УТХО-ын гүйцэтгэлийн судалгаа	22
Хүснэгт 3	Барьцаа хөрөнгийн санхүүгийн баримт, аудиторын судалгаа	22
Хүснэгт 4	Барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн	23
Хүснэгт 5	Аудитын судалгаа	26
Хүснэгт 6	Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний судалгаа	27
Хүснэгт 7	Ажил гүйцэтгэх гэрээ, судалгаа	30
Хүснэгт 8	Ажлын баримт дансны судалгаа	32
Хүснэгт 9	Ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт	33

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоолын дагуу хийнэ.

Аудитын зорилт

Баян-Өлгий аймагт хэрэгжсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төөвлөсөн эсэх,
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх,

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд санхүүжүүлэхээр баталсан 43 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон бусад байгууллага, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС-100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглав.(Асуудлын шинжилгээ хавсралт №2, аудитын загварын матрицыг хавсралт №-3-т үзүүлэв.)

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, аудитор С.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 13-ны хооронд гүйцэтгэж, тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ҮАГ-т, 04 дүгээр сарын 24-ний дотор холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

Талбарын ажлыг гүйцэтгэх үе шат санхүүгийн тайлангийн аудитын дараа богино хугацаанд төлөвлөгдсөн тул ачаалалтай ажилласан, хугацааны хувьд богино байв.

А.ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ НИЙЦСЭН БОЛОВЧ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТАД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА

А.1. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ нь Монгол Улсын урт болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй 54.5-95 хувь уялдсан байна

А.1.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 95 хувь нь “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-той нийцсэн байна

Улсын төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжихээр төлөвлөсөн 22 төсөл арга хэмжээ нь “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой нийцэж байгаа эсэхийг тулган шалгалаа.

- Сумын төвийн гэрэлтүүлэг /Баян-Өлгий, Ногооннуур сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтанцөгц сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/, Уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/, Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/, Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/ ажил нь “Алсын хараа- 2050 МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын 8.2.4-т нийцсэн байна.
- Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/ төсөл арга хэмжээ нь 6.3.1.4-т нийцсэн
- Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/, Дотуур байрны барилга, 100 ор /Баян-Өлгий, Алтанцөгц сум/, Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/, Сургуулийн дотуур байрны барилга, 30 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, 2 дугаар баг/, Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Булган сум, 4 дүгээр баг/, Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 5 дугаар баг/, Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Өлгий, Сагсай сум, 5 дугаар баг/, Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Өлгий, Улаанхус сум/ ажил нь 2.1.1.2-т нийцсэн байна.
- Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/ ажил нь 8.2.4, 8.1.8-т нийцсэн байна.
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/, сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтанцөгц сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/, Уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/, Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/, Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/ зэрэг ажил нь 8.2.4-т нийцсэн.
- Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум, 1, 2, 3, 4, 5, 6, 8 дугаар сургууль/, Аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвийн

компьютер, тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/ ажил нь 9.1.1.1-т нийцсэн.

- Номын сангийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/ ажил нь 1.1.2.3-т нийцсэн.

Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ нь Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдаагүй байна.

А.1.2. Батлагдсан төсөл арга хэмжээ нь Монгол Улсын 2021-2025, аймгийн 2021-2025 оны үндсэн чиглэлд нийцсэн боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн 63.6 хувь нь тусгагдаагүй байна

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 359 дүгээр тогтоолоор Баян-Өлгий аймагт нийт 22 төсөл арга хэмжээг эрх шилжүүлсэн байна. Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээг багцаар нь ангилбал:

- ЗГХЭГ-ын даргын багцаас 1, БХБС-ын багцаас 2, БШУС-ын багцаас 9, ЗТХС-ын багцаас 6, ЭМС-ны багцаас 1, Соёлын сайдын багцаас 1, ЭХС-ын багцаас 2 төсөл арга хэмжээг тус тус эрх шилжүүлсэн байна.

ТЕЗ-аас 2022 онд эрх шилжүүлсэн 22 төсөл арга хэмжээг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Баян-Өлгий аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн баримт, Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.5, 5.1.6 дахь заалтыг үндэслэн төлөвлөсөн эсэхийг шалгаж үзэхэд:

А. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.2.7, 4.2.8, 6.3.3, 9.1.1, 8.1.3, дахь заалтад тусгагдсан байна.

Б. Баян-Өлгий аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн баримт бичгийн 2.1.8, 4.2.2, 5.1.1, 8.1.1, 8.1.3, 8.1.7 дахь заалтад тусгагдсан байна.

В. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт БШУС-ын эрх шилжүүлсэн 8 төсөл арга хэмжээ тусгагдаж, бусад сайдуудын багцаас эрх шилжүүлсэн дараах 14 төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнд:

- Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/, Сумын төвийн гэрэлтүүлэг /Баян-Өлгий, Ногооннуур сум/, Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/, Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/, Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум, 1, 2, 3, 4, 5, 6, 8 дугаар сургууль/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтанцөгц сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/, Хотгорын уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/, Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/, Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/, Номын сангийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/ зэрэг 14 төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 22 төсөл арга хэмжээг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Баян-Өлгий аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн баримт бичигт нийцүүлж төлөвлөсөн боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 14 төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна.

А.1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 54.5 хувь нь улсын бодлогод, 91.7 хувь нь аймгийн Хөгжлийн төлөвлөгөөнд нийцэж, эерэг өөрчлөлт бий болох нөхцөл бүрэлдсэн байна

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 13 дугаар тогтоолоор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг, мөн өдрийн 14 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталсан байна.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Аймгийн Хөгжлийн төлөвлөгөөг гаргаж, жил тус бүр аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж, холбогдох байгууллагуудад тайлагнаж ажилласан байна.

Аймгийн Хөгжлийн төлөвлөгөөнд 123 заалт бүхий зорилт дэвшүүлэн биелэлтийг нь гаргасны дотор улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл арга хэмжээ, барилга байгууламж, зам гүүр барих, үерийн далан барих, хатуу хучилттай зам тавих, хот тохижилтын парк байгуулах, ард иргэдийг цэвэр ундны усаар хангах зэрэг ажлуудыг тусгасан байна.Тухайлбал:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих 22 төсөл арга хэмжээний 19 нь аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаж, шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 24 төсөл арга хэмжээний 21 нь хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаж, хэрэгжилтийг тайлагнаж ажилласан байна. Дараах 3 төсөл арга хэмжээ нь аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.Үүнд:

- Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум, 1, 2, 3, 4, 5, 6, 8 дугаар сургууль/
- Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/
- Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/

Аймагт шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, эрх шилжсэн 22 төсөл арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн эсэхийг шалгаж үзэхэд 12 төсөл арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаж, 10 төсөл арга хэмжээ нь тусгагдаагүй байна.Үүнд:

- Сумын төвийн гэрэлтүүлэг /Баян-Өлгий, Ногооннуур сум/
- Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/
- Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтай сум/
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Алтанцөгц сум/
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/

- Хотгорын уурхай, Сагсай сум чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, 1.6 км /Баян-Өлгий, Өлгий, Сагсай сум/
- Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/
- Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/
- Номын сангийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 төсөл арга хэмжээний 54.5 хувь нь Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, 91.7 хувь нь аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байна.

A.2. ТӨЛӨВЛӨСӨН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТАД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА

A.2.1. Шинээр хэрэгжих 22 төсөл арга хэмжээ нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой төсөл арга хэмжээ байна

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 төсөл арга хэмжээний 18 барилга байгууламж, 4 тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээ нь тухайн шатны төсөвт байгууллага, орон нутгийн засаг захиргаанд өмчлөлд шилжүүлэх боломжтой төсөл арга хэмжээ байна.

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний нийт төсөвт өртөг нь 48,049.7 сая төгрөг, гэрээний үнийн дүн нь 47,722.7 сая төгрөг байна.

A.2.2. Аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслээгүй 10 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнд оруулж баталсан байна

Аймгийн Засаг дарга нь сумын Засаг дарга, харьяа агентлагуудын дарга нараас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүсэлтийг нь авсан байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс аймгийн Засаг даргын харьяа агентлаг, сумын Засаг дарга нараас ирүүлсэн нийт 39 төсөл арга хэмжээний саналыг Сангийн Сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын дагуу үнэлж, 40.5-71.0-ийн хооронд оноо өгч эрэмбэлсэн жагсаалт үйлдсэн байна.

Төсвийн тухай хуулиар баталж, эрх шилжүүлсэн шинээр хэрэгжих 22 төсөл арга хэмжээний 12 төсөл арга хэмжээг аймгийн ТЕЗ-аас хүргүүлсэн саналд үндэслэж, 10 төсөл арга хэмжээг ТЕЗ-ийн саналд үндэслээгүй баталж ирүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, тухайн төсөл арга хэмжээг төлөвлөх үед ажиллаж байсан мэргэжилтэн нар нь ажлаас гарснаас шалтгаалж аудитын явцад Засаг дарга, түүний харьяа агентлагууд, сумдын Засаг дарга нараас ирүүлсэн саналын анхан шатны баримт материал, холбогдох хавсралт материалуудтай танилцах боломжгүй байсныг дурдаж байна.

Иймд төлөвлөлтийн шатны явцтай холбоотой баримт материалын бүрдүүлэлт, баримтжуулалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөгдлөө.

А.2.3 Батлагдсан төсөл арга хэмжээний 38.8 хувийн зураг төсөв нь төлөвлөлтийн шатанд бэлэн болоогүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 22 төсөл арга хэмжээний 18 нь барилга байгууламж барих, 4 нь тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлэх төсөл арга хэмжээ байна.

Барилга байгууламж барих 18 төсөл арга хэмжээний 7 төсөл арга хэмжээний зураг төсөв нь төлөвлөлтийн шатанд бэлтгэгдэж, 4 төсөл арга хэмжээг нэг маягийн зураг төсвөөр барихаар төлөвлөсөн ба 7 төсөл арга хэмжээ нь зураг төсөвгүй байжээ. Зураг төсөвгүй байсан төсөл арга хэмжээ нь:

- Сумын төвийн гэрэлтүүлэг /Баян-Өлгий, Ногооннуур сум/
- Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/
- Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/
- Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж /Баян-Өлгий, Цэнгэл сум/
- Сургуулийн дотуур байрны барилга, 30 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, 2 дугаар баг/
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 5 дугаар баг/
- Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/

Техникийн нөхцөл олгогдоогүй байсан 8 төсөл арга хэмжээг баталсан байна.Үүнд:

- Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/
- Дотуур байрны барилга, 100 ор /Баян-Өлгий, Алтанцөгц сум/
- Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/
- Сургуулийн дотуур байрны барилга, 30 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, 2 дугаар баг/
- Сургуулийн спорт заалны барилга /Баян-Өлгий, Булган сум, 4 дүгээр баг/
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/
- Бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/
- Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/

Газрын зөвшөөрөл олгогдоогүй 3 төсөл арга хэмжээ байна.Үүнд:

- Дотуур байрны барилга, 100 ор /Баян-Өлгий, Алтанцөгц сум/
- Сумын төвийн хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, 2.3 км /Баян-Өлгий, Толбо сум/
- Тоорцог толгойн төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Бугат сум/

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд батлагдсан төсөл арга хэмжээний 38.8 хувийн зураг төсөв нь төлөвлөлтийн шатанд бэлэн болоогүй, 44.4 хувьд нь техникийн нөхцөл олгогдоогүй, 16.7 хувьд нь газрын зөвшөөрөл олгогдоогүй байсан байна.

Дээрх зөрчлүүдийг арилгах талаар албан шаардлага өгөгдлөө.

А.2.4 Барилга байгууламжийн 5 төсөл арга хэмжээний төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар дүгнэлт гараагүй байна

Шинээр хэрэгжих 22 төсөл арга хэмжээний 18 төсөл арга хэмжээ нь барилга байгууламжийн төсөл арга хэмжээ, 4 нь тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээ байна.

Барилга байгууламжийн 18 төсөл арга хэмжээний 10 төсөл арга хэмжээ нь ашиглалтад ороход орон тоо ажиллуулж, урсгал зардал гарч төсөвт нөлөө үзүүлэхээргүй гэрэлтүүлэг, цэвэр усны шугам, цахилгаан хангамж, хатуу хучилттай автозам, гүүр барьж байгуулах зэрэг арга хэмжээнүүд байна.

Барилга байгууламж барих 8 төсөл арга хэмжээний 3 нь хуучин барилга байгууламжийг шинэчлэх зориулалтаар, 5 нь шинээр барьж байгуулах төсөл арга хэмжээ байна.

Эдгээр шинээр барьж байгуулах 5 төсөл арга хэмжээний ашиглалттай холбоотой гарах урсгал зардал болон төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар дүгнэлт гараагүй байна. Эдгээр нь:

- Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/
- Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум, 5 дугаар баг/
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Өлгий, Сагсай сум, 5 дугаар баг/
- Цэцэрлэгийн барилга, 150 ор /Баян-Өлгий, Улаанхус сум/

А.2.5. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн зарим заалтыг мөрдөж ажиллаагүй байна

Шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 22 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримталсан эсэхийг шалгаж үзэхэд:

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 төсөл арга хэмжээний 1 төсөл арга хэмжээг шууд худалдан авах замаар, 21 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулсан байна.

Төсөл арга хэмжээнүүдийн үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамжаар 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 02 дугаар сарын 23-ны хооронд байгуулж, тендерийг 02 дугаар сарын 01-ээс 02 дугаар сарын 25-ны дотор зарласан боловч 7 тендер сонгон шалгаруулах үйл ажиллагаанд маргаан гарсан байна.

Тендерээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны явцыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулж, гэрээний эрх олгох хугацааг 2022 оны 3 дугаар сарын 10-аас 5 дугаар сарын 25-ны дотор олгож, ажил гүйцэтгэх гэрээг 01 дүгээр сарын 15-аас 6 дугаар сарын 03-ны хооронд хийж гүйцэтгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Төрийн хэмнэлтийн тухай

хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан хугацаанд зохион байгуулж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-д заасан нөхцөл байдал үүсээгүй байна. Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлууд нь гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэгдэж, хугацаа болоогүй ажлууд нь үргэлжлэн хийгдэж байна.

Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалтыг зөрчсөн ашиглалтын хугацаа дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж барих санал тусгагдаагүй байна.

Хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1, 13.3.2 дахь заалтыг зөрчсөн хөшөө, дурсгал, угтах үдэх хаалга барих, хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид шилжих боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна.

Шинээр хэрэгжих барилга байгууламж барих 7 төсөл арга хэмжээний зураг төсөл нь бэлэн болоогүй, 3 төсөл арга хэмжээний газрын зөвшөөрөл олгогдоогүй, 8 төсөл арга хэмжээний техникийн нөхцөл олгогдоогүй байсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.1, 3.2.2.2 дахь заалтыг зөрчиж байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөгдлөө.

Б.1. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА

Б.1.1. ТЕЗ-даас төсөл, арга хэмжээг хуульд заасан хугацаандаа эрх шилжүүлж, худалдан авах ажиллагааг хугацаанд зарласан боловч төлөвлөсөн хугацааг дунджаар 44 хоногоор хоцроожээ

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 22 төсөл, арга хэмжээний эрхийг тус аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 03 дугаар тушаалаар 1 төсөл, арга хэмжээ, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн А/430 тоот тушаалаар 9 төсөл, арга хэмжээ, Эрчим хүчний сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/262 дугаар тушаалаар 2 төсөл, арга хэмжээ, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн А/03 дугаар тушаалаар 1 төсөл, арга хэмжээ, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн тушаалаар 2 төсөл, арга хэмжээ, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/186 дүгээр тушаалаар 6 төсөл арга хэмжээ, Соёлын сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/287 дүгээр тушаалаар 1 төсөл арга хэмжээний эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Хүснэгт №01

№	ТЕЗ-ын нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Эрх шилжүүлэх эцсийн хугацаа	Эрх шилжүүлсэн хугацаа	Хугацаа хоцроож шилжүүлсэн хугацаа
1	ЗГХЭГ	1	2021.01.11	2022.01.07	0
2	БШУСайд	9	2021.01.11	2021.12.08	0
3	ССайд	1	2021.01.11	2021.12.10	0
4	ЭМСайд	1	2021.01.11	2022.01.06	0
5	ЗТХСайд	6	2021.01.11	2021.12.07	0
6	БХБСайд	2	2021.01.11	2021.12.01	0
7	ЭХСайд	2	2021.01.11	2021.12.10	0
	Нийт	22			0 хоног

Эх сурвалж: ТЕЗ-даас эрх шилжүүлсэн ТАХ-ний нэгдсэн судалгаа

Төсвийн ерөнхийлөн захирагчид Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын 2.13-д заасны дагуу төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хугацаандаа эрх шилжүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хуулийн хугацаандаа эрх шилжүүлснээр хэрэгжих төсөл арга хэмжээний тендер зарлах хугацаа нь төлөвлөсөн хугацаанд зохион байгуулагдах давуу талтай.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн 22 төсөл арга хэмжээний 21 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанаас дунджаар 44 хоногоор хоцроож тендер зарлаж, гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлснээс хойш дунджаар 23 хоногоор хоцроож гэрээ байгуулсан байна.

Дээрх 21 төсөл арга хэмжээний тендер төлөвлөсөн хугацаанаас 3-72 хоногоор хугацаа хожимдож зарлагдсан байна.

Б.1.2. Тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулсан байна

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь нээлттэй тендер шалгаруулалтын аргаар бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягтыг Сангийн сайдын 2021 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 175 дугаар тушаалын хавсралтаар, харьцуулалтын аргаар бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг Сангийн сайдын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 124 дугаар тушаалын хавсралтаар баталсан тендерийн жишиг баримт бичгийг боловсруулах зааврыг ашиглан цаасаар болон цахим хэлбэрээр бүрдүүлэн ажилласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 21 төсөл арга хэмжээний бараа, ажил үйлчилгээг худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж, 1 төсөл арга хэмжээг шууд худалдан авах замаар тендер гүйцэтгэгчийг шалгаруулсан байна.

Тайланд онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 21 төсөл, арга хэмжээний 7 буюу 33.3 хувьд тендер сонгон шалгаруулахтай холбоотой гомдол гарсан нь өмнөх онтой харьцуулахад буурсан үзүүлэлтэй байна.

Тендерийн бичиг баримтыг хууль журамд нийцүүлэн боловсруулсан эсэх, худалдан авах ажиллагааг зохих журмын дагуу хэрэгжүүлсэн эсэхийг шалгаж үзэхэд тайлант оны тендер шалгаруулалттай холбоотой тендерт оролцогч компаниудаас Сангийн яамд 7, Шүүхэд 2 гомдол гаргасан байна. Тухайлбал:

Ногооннуур сумын 160 суудалтай бага сургууль, Ногооннуур сумын 30 ортой дотуур байр, Өлгий сумын 100 ортой цэцэрлэг, Улаанхус сумын 150 ортой цэцэрлэг ийн барилга угсралтын ажил, Өлгий сумын Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар сургуулийн тоног төхөөрөмж нийлүүлэх зэрэг 7 төсөл арга хэмжээний тендер сонгон шалгаруулалттай холбоотой Сангийн яамд гомдол гаргаж, Сангийн яам Үнэлгээний хороонд тендерт оролцогч компаниудын бичиг баримтад дахин үнэлгээ хийх чиглэл хүргүүлсэн байна.

Үнэлгээний хороо тендерт оролцсон компаниудын бичиг баримтад дахин үнэлгээ хийж, 6 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг хэвээр баталж, 1 төсөл арга хэмжээ буюу Өлгий сумын Ерөнхий боловсролын 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дугаар сургуулийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг гүйцэтгэгчээр өөр компани буюу “Санхомакетинг” ХХК-ыг шалгаруулсан байна.

“Көшелик” ХХК Цэнгэл сумын 320 суудалтай сургуулийн барилгын тендер шалгаруулалттай холбоотой шийдвэрийг, “Ховд баганат” ХХК Алтанцөгц сумын 100 ортой дотуур байрны барилгын тендер шалгаруулалттай холбоотой шийдвэрийг үл зөвшөөрөн Сангийн яам болон Захиргааны хэргийн анхан шат, давж заалдах шатны шүүхэд тус тус гомдол гаргасан байна.

Сангийн яамнаас дээрх компаниудын бичиг баримтад үнэлгээ хийх чиглэл ирүүлсний дагуу дахин үнэлсэн бөгөөд Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны давж заалдах шатны шүүхээс гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Б.1.3. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас Баян-Өлгий аймгийн Засаг даргад 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламж барих 18, тоног төхөөрөмж нийлүүлэх 3, бүгд 21 ажлын эрхийг шилжүүлж, бараа ажил үйлчилгээг худалдан авах тендерийн гүйцэтгэгчийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар тендерийн үнэлгээний хороог 2022 оны 01 дүгээр сарын 17-ноос 2 дугаар сарын 23-ны хооронд байгуулан, тендерийг 01 дүгээр сарын 18-наас 4 дүгээр сарын 04-ний хооронд зарлаж, хуулийн хугацааг баримталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “батлагдсан төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” гэсэн заалттай нийцсэн байна.

Тус аймгийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг tender.gov.mn сайтад нээлттэй байршуулан ажил үйлчилгээ, бараа худалдан авах тендерийн урилга болон холбогдох баримтуудыг “tender.gov.mn”, “tender.bo.gov.mn” сайтад

нээлттэй байршуулан, тендер шалгаруулалтын үр дүнг тус сайтад мэдээлж ажилласан байна.

Үүнээс үзэхэд тендер шалгаруулалттай холбоотой мэдээллийг ил тод мэдээлж, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна.

Б.2. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ ҮР ДҮНТЭЙ БАЙНА

Б.2.1 Барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэсэн байна

Аймгийн Засаг дарга нь 2022 онд эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын 22 төсөл арга хэмжээ, шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 21 төсөл арга хэмжээ, бүгд 43 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна. Үүнээс: барилга байгууламж барих 38 төсөл арга хэмжээ, тоног төхөөрөмж нийлүүлэх 5 төсөл арга хэмжээ байна.

Барилга байгууламж барих 38 төсөл арга хэмжээний 18 төсөл арга хэмжээ нь шинээр хэрэгжих, 20 төсөл арга хэмжээ нь шилжих хөрөнгө оруулалт байна. Үүнээс гэрээнд тусгагдсны дагуу 2022 онд хэрэгжиж дуусах 14 төсөл арга хэмжээ байгаагаас 6 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, нэмэлт гэрээгээр 8 төсөл арга хэмжээний хэрэгжих хугацааг сунгасан байна. Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/ ажлыг 2022 онд хийж хүлээлгэн өгсөн байна.

Хэрэгжиж дууссан тоног төхөөрөмж нийлүүлэх 5 төсөл арга хэмжээг улсын комиссын актаар захиалагч байгууллагууд ашиглалтад хүлээн авч, Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ ажлын 1, 2, 3, 4 дүгээр багцын ажил бүрэн хэрэгжиж дууссан байна.

Аудитын явцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг Сагсай, Цэнгэл, Улаанхус, Цагааннуур тосгон, Улаанбайшинт боомт, Ногооннуур, Өлгий, Бугат сумдад газар дээр үзэж танилцаж, зурагжуулж баримтжуулж ажилласан.

Шинээр болон шилжих хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн хэрэгжилтийн байдал дараах байдалтай байна.Үүнд:

Сумын төвийн гэрэлтүүлэг /Баян-Өлгий, Ногооннуур сум/, Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/, Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/, Сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.1 км /Баян-Өлгий, Өлгий сум/, Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ багцын 1-4 дүгээр багц ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан байна.

1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/, Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил 16 км /Баян-Өлгий, Өлгий/, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/ зэрэг төсөл арга хэмжээний хэрэгжилтийг 95-98.3 хувьтай гэж тодорхойлсон байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга, Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгын ажил бүрэн дуусаж барилгыг ашиглалтад оруулахад бэлэн болсон байна.

1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил, Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил 16 км төсөл арга хэмжээний ажил дуусах шатандаа орсон байна.

Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах 5 дугаар багцын ажил нь 1 дүгээр багцын кабель нийлүүлэх ажлаас шууд хамааралтай, кабель татах ажил байсан бөгөөд 1 дүгээр багцын нийлүүлэх кабель нь оны эцэст ирсэн тул хийгдээгүй байна.

Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/ барилгын ажил тендерийн маргаанаас болж тайлант онд эхлээгүй байна.

Төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд захиалагчийн болон холбогдох газрын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд барилга байгууламжийн ажлууд нь холбогдох норм, стандарт, батлагдсан зураг төсвийн дагуу хийгдсэн байна. Төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг газар дээр шалгаж үзэхэд дараах байдалтай байна.Үүнд:



Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/, ажлын гүйцэтгэл 99.7 хувьтай.



1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/, ажлын гүйцэтгэл 98.28 хувьтай байна.



Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил 16 км /Баян-өлгий, Өлгий/, ажлын гүйцэтгэл 97.7 хувьтай.



Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/, 4-р баг, ажлын гүйцэтгэл 58.6 хувьтай.



Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/, ажлын гүйцэтгэл 63.27 хувьтай.



Бага сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Ногооннуур сум, 6 дугаар баг/, ажлын гүйцэтгэл 20 хувьтай байна.

Олон жил дамжин хэрэгжиж буй 7,501.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгын /Баян-Өлгий, Өлгий сум/ ажил бүрэн дууссан боловч оны эцэст захиалагчийн хүсэлтээр зарим ажлыг нэмж гүйцэтгэж ашиглалтад ороход бэлэн болсон байна. Гэтэл тодорхой шалтгаанаар Улсын комисс томилоогүй, барилгыг ашиглагтад хүлээж аваагүйгээс Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд орох төсөвт байгууллагууд орон байргүйн улмаас төсвөөс түрээсийн төлбөр төлж үргүй зардал гаргасаар байгаа зөрчлийг арилган, барилгыг ашиглалтад оруулах тухай албан шаардлага өгөгдлөө.

Б.2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд их засварын ажил тусгагдаагүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 22 төсөл арга хэмжээний дотор их засварын ажил тусгагдаагүй байна.

Б.2.3. Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж нь баталсан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай нийцсэн байна

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,948.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх 5 төсөл арга хэмжээ хэрэгжсэний 4 нь шинээр хэрэгжих, 1 нь он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь:

- Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/,
- Аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвийн компьютер, тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/
- Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум, 1, 2, 3, 4, 5, 6, 8 дугаар сургууль/
- Номын сангийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/
- Хот тохижилтын парк шинэчлэл /Баян-Өлгий, Өлгий сум/

Тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээ нь ажлын даалгаврын дагуу гэрээнд заасан хугацаанд 100% хэрэгжиж, ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.

Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж, Сургуулийн тоног төхөөрөмж, Номын сангийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээг ажлын даалгаврын дагуу хугацаанд нь нийлүүлсэн байна.

Аймгийн төвийн Өрхийн эрүүл мэндийн төвийн компьютер, тоног төхөөрөмж, Хот тохижилтын парк шинэчлэл төсөл арга хэмжээний гэрээний хугацааг 6 сараар сунгаж, гэрээг сунгасан хугацаанд тоног төхөөрөмжөө нийлүүлэн, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг захиалагч байгууллагаас гаргасан техникийн тодорхойлолт, ажлын даалгавартай тулгаж үзэхэд зөрчил дутагдал илрээгүй, ашиглагч байгууллагууд нь тоног төхөөрөмжийг орлогод авч бүртгэсэн байна.

Б.2.4. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд ТЭЗҮ ангилалтай төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний дотор ТЭЗҮ ангилалтай төсөл арга хэмжээ батлагдаагүй байна.

Б.2.5 Он дамжсан дуусаагүй орхигдсон төсөл, арга хэмжээ байхгүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний дотор хэрэгжиж байгаа боловч орхигдсон төсөл арга хэмжээ байхгүй байна.

Өнгөрсөн онд хийгдсэн улсын төсвийн төсвийн хөрөнгө оруулалтын аудитын судалгаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дуусаагүй, орхигдсон барилга байгууламжийн судалгаанд Өлгий сумын 7 дугаар баг Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 20 ортой барилгын ажил орсон.

Орхигдсон шалтгаан нь анх 2019 онд 250.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй тендер зарлагдаж, тухайн онд хүйтний улиралд гэрээ хийгдэж, барилгын ажил бүрэн хийгдээгүй тул ашиглалтад ороогүй байна. Гүйцэтгэгч нь 2019 оны жилийн эцэст Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор банкны барьцаагаар нийт санхүүжилтийг авсан. Харин магадлалаар баталгаажсан төсөвт өртөг нь 1003.3 сая төгрөг болсон байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн эрүүл мэндийн сайдын багцад тус төсөл арга хэмжээний төсөвт өртөг 1003.3 сая төгрөгөөр батлагдаж, тайлант онд санхүүжих дүн 50.0 сая төгрөг тусгагджээ.

Б.3 САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРАМД НИЙЦҮҮЛЭН ОЛГОСОН БАЙНА

Б.3.1. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Засгийн газрын 2021 оны 160 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.5, 4.1.6-д заасны дагуу гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн захиалагч 7, 8, 9-д заасан маягтуудыг баталж, санхүүжилт хүссэн албан бичгийн хамтаар Сангийн яаманд хүргүүлсэн байна. Сангийн яам журмын 4.1.7-д заасны дагуу санхүүжилтийн эрхийг нээж, санхүүжилтийг олгож ирсэн байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ажлын гүйцэтгэл, “хяналтын хуудас”, ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэл зэрэг нотлох баримтуудыг үндэслэн урьдчилгаа болон эцсийн санхүүжилтийг журамд заасан хугацаанд олгосон байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд эрх шилжсэн 95,699.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 43 төсөл арга хэмжээний гэрээний дүн 92,614.9 сая төгрөг байна. Уг төсөл арга хэмжээнүүдэд ажил эхэлснээс хойш олгосон санхүүжилт нь 46,514.4 сая төгрөг бөгөөд тайлант онд 28,896.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Санхүүжилт олгосон байдлыг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр харуулбал.

Хүснэгт № 2				/сая төгрөгөөр/		
ТЕЗ-ийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Ажил эхэлснээс хойшхи санхүүжилт	2022 онд гүйцэтгэгчид олгосон санхүүжилт	Хувь
ЗГХЭГ	2	7551.4	7551.2	7530.8	2080.8	28%
ХНХС	1	1,930.00	1,910.00	1814.5	1486.4	82%
ХХААХҮС	1	1,913.20	1,903.40	1810.9	1310.9	72%
БСШУССайд	19	43438.8	41205.2	13722.1	10450.1	76%
Эрүүл мэндийн сайд	2	547.60	378.90	487.7	170.0	35%
БХБСайд	6	10,668.30	10159	9984.7	4911.0	49%
ССайд	2	1723.4	1717.6	1708.0	1708.0	100%
ЗТХС	7	20426.9	20303.9	8678.9	6085.3	70%
ЦХХХС	1	600.00	585.7	416.8	333.7	80%
ЭХС	2	6900.00	6900.00	360.00	360.00	100%
Нийт	43	95699.6	92614.9	46514.4	28896.2	

Эх сурвалж: УТХО-ын гүйцэтгэлийн судалгаа

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээс 2021 оны жилийн эцэст 6 сайдын 10 төсөл арга хэмжээний 3,655.7 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн байна. Үүнээс 2022 онд өмнөх оны ажлын гүйцэтгэлийг үндэслэн 6 сайдын 11 төсөл арга хэмжээнд 3,224.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт №3			/мянган төгрөгөөр/	
д/д	Яамны багц	Төсөл арга хэмжээний нэр	2021 оны жилийн эцсээр төвлөрүүлсэн дүн	2022 онд олгосон дүн
1	ЗГХЭГ	Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ 1-р багц, 5-р багцын санхүүжилтийг барьцаа дансанд байршуулсан.	332,926.60	167,000.00
2	.ЭМСайдын	/Сүвэн уул" ХХК/-тоног төхөөрөмж нийлүүлэх	19,445.00	19,445.00

3	БШУСайд	Цэцэрлэгийн барилга, 250 ор /Баян-Өлгий, өлгий сум/ Мурап ХХК 501,413,400	501,413.40	501,413.40
4	БШУСайд	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/ -Көшелик ХХК 400,000,000	400,000.00	400,000.00
5	БШУСайд	Ногооннуур сумын Улаанбайшингийн 50 ортой цэцэрлэгийн санхүүжилт 356,460,128	356,460.10	97,405.20
6	БШУСайд	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, өлгий сум/-Классиксалушн ХХК 300,000,000	300,000.00	300,000.00
7	ЭМСайд	Багийн Эрүүл мэндийн төвийн барилга 5 ортой, Ногооннуур сум, Улаанхад баг , "Бапкер" ХХК-барьцаа	41,226.10	41,226.10
8	БХБСайд	Хот тохижилтын парк шинэчлэл /Баян-Өлгий, Өлгий сум/-Алтайн үндэс констракшн	700,000.00	699,955.00
9	ССайд	Соёлын төвийн барилга-Толбо сум	1,000,000.00	992,396.90
10	ЭМСайд	Улаанхус ЭМТ-ийн тоног төхөөрөмжийн нийлүүлэх ажлын барьцаа	4,250.00	-
11	ХНХС	PIMIS22003938,Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/,МОНСТРОЙ-ЭРА		5,841.00
Нийт дүн			3,655,721.20	3,224,682.60

Эх сурвалж: Барьцаа хөрөнгийн санхүүгийн баримт, аудиторын судалгаа

Барьцаа хөрөнгийн дансанд 2022 оны эцэст 6 сайдын 15 төсөл арга хэмжээний дутуу олгогдсон 222.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна Үүнд:

Хүснэгт №4		/мянган төгрөгөөр/	
д/д	Сайдын багц	төсөл арга хэмжээний тоо	төвлөрүүлсэн санхүүжилт
1	ЗГХЭГ	1	24,706.20
2	БШУСайд	8	114,233.20
3	ЭМСайд	1	55,977.40
4	БХБСайд	3	9,241.90
5	ХНХСайд	1	1,140.70
6	ССайд	1	17,698.60
Нийт дүн		15	222,998.10

Эх сурвалж: Барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн

Б.3.2 Нийт 16 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх хугацааг нэмэлт гэрээгээр сунгасан байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 16 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх хугацааг нэмэлт гэрээгээр сунгасан байна. Энэ нь тодорхой шалтгааны улмаас ажлаа хугацаанд гүйцэтгэх боломжгүй болсон, 2023 оны төсвийн тухай хуульд төсөв нь нэмэгдэж батлагдсан, эсхүл магадлангаар баталгаажсан төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл арга хэмжээнүүд байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь:

- 1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил /Баян-Өлгий, Өлгий/
- Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил 16 км /Баян-өлгий, Өлгий/

- Сургуулийн барилга, 320 суудал /Баян-Өлгий, Цэнгэл сум/
- Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/
- Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/
- Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/
- Цэцэрлэгийн барилга, 120 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/
- Цэцэрлэгийн барилга, 250 ор /Баян-Өлгий, Өлгий сум/
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Баяннуур сум, "Ак арал" баг/
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Булган сум, Сайхан баг/
- Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаанбайшинт боомт/
- Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Толбо сум/
- Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/
- Багийн эрүүл мэндийн төвийн барилга, 5 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаанхад баг/
- Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ 5 дугаар багц

Эдгээр төсөл арга хэмжээнүүдийн нэмэлт гэрээ хуулийн хүрээнд хийгдсэн байна.

Б.4. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ ЗОХИХ ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА

Б.4.1. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагаас хяналтыг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна

Аймгийн Засаг дарга ГХБХБГ-ын даргатай 2022 оны 03 дүгээр сарын 01-ны өдөр улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт 39 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхээр 01 тоот гэрээ байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/04 дүгээр захирамжаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга, засварын ажлын захиалагчийг томилж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 11 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон байна.

Аймгийн Засаг даргын дээрхи захирамжийг үндэслэн Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Барилга, захиалагчийн албатай 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр гэрээ байгуулж, Аймгийн Засаг даргаар батлуулан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 11 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд техникийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

ГХБХБГ, Барилга захиалагчийн алба нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний хяналтыг хууль журмын дагуу хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал:

ГХБХБГ, Барилга захиалагчийн алба нь барилга байгууламжийн үе шат болгонд хэрэгжүүлэх техникийн хяналтыг графикт хугацаанд нь тавьж, илэрсэн

зөрчлийг барилга байгууламжийн талбайн хяналтын дэвтэрт тухай бүрт тэмдэглэж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжсэн барилга, засварын ажлын 1 төсөл, арга хэмжээнд “Монхидро констракшн” ХХК, 12 төсөл, арга хэмжээнд “АЕСН” ХХК, 2 төсөл, арга хэмжээнд “Бодит чадал” ХХК, 1 төсөл, арга хэмжээнд “Рус-Нур” ХХК, 2 төсөл, арга хэмжээнд “Премиум проект” ХХК, 1 төсөл, арга хэмжээнд “Кинг сий инженер энд консалтинг групп” ХХК, 2 төсөл, арга хэмжээнд “Жаргалант хийц” ХХК, 1 төсөл, арга хэмжээнд “Бюдингс технологи” ХХК, 1 төсөл, арга хэмжээнд “Тод прогресс” ХХК, 1 төсөл, арга хэмжээнд “ТГТ” ХХК, 1 төсөл, арга хэмжээнд “Аркон” ХХК, 3 төсөл, арга хэмжээнд “Зэт прожект” ХХК, 1 төсөл, арга хэмжээнд “Энх энэрлийн өргөө” ХХК-иуд зураг төсөв зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Алтай сумын төвийн хатуу хучилттай авто зам, Алтанцөгц сумын төвийн хатуу хучилттай авто зам, Толбо сумын төвийн 2.3 км хатуу хучилттай авто зам, явган хүний зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалт, өөрчлөлтийн ажил, Уурхай, Сагсай сумын 1.6 км чиглэлийн авто зам, гэрэлтүүлэг, шугам сүлжээ, Улаанхус сумын Хөх хөтөл багийн бетон гүүр, Бугат сумын Тоорцог толгойн төмөр бетон гүүр зэрэг 6 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зөрчлийг арилгуулж ажилласан байна.

ГХБХБГ-аас төсөл арга хэмжээнүүдийн үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ажлын явцын мэдээллийг баримтжуулж, гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар товч мэдээлэл бэлтгэж зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж, үүрэг даалгавар өгч ажилласан байна.

Төсөл арга хэмжээний санхүүгийн баримт материал, санхүүжилт хүссэн ажлын гүйцэтгэлийн баримтаар захиалагчийн болон зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн ажлын баримтуудыг хавсаргаж, уг баримт материалыг үндэслэн хяналтын зардлыг Санхүү, төрийн сангийн хэлтсээс олгож ирсэн байна.

Б.4.2. Хөрөнгө оруулалтын явцад Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна

Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийг олгоход үе шатны хяналтыг хэрэгжүүлж, холбогдох журмыг мөрдөж ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.1.5-д заасны дагуу захиалагчийн санхүүжилт хүссэн материалыг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн хянан баталгаажуулсны дараа албан бичгээр холбогдох гүйцэтгэлийн материалын хамт Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамнаас санхүүжилтийн эрхийг нээж Санхүү, төрийн сангийн хэлтсээс санхүүжилтийг хугацаанд олгож ирсэн байна.

Зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг холбогдох материалыг үндэслэн шилжүүлжээ.

Б.5. Төсөл арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна

Б.5.1. Төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс нь өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэж, холбогдох хууль, дүрмийн дагуу дүгнэлт гаргаж, хүлээн авсан байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 10 төсөл, арга хэмжээний 2 нь 2020, 2021 онд ашиглалтад орсон, 2022 онд 8 төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.

2020, 2021 онд ашиглалтад орсон төсөл арга хэмжээ нь:

- Сургуулийн барилга, 160 суудал /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөх хөтөл баг/
- Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.1 км /Баян-Өлгий, Өлгий сум/ байна.

2022 онд ашиглалтад хүлээн авсан 8 төсөл арга хэмжээ нь:

- Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/
- Сумын төвийн гэрэлтүүлэг /Баян-Өлгий, Ногооннуур сум/
- Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/
- Аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвийн компьютер, тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/
- Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум, 1, 2, 3, 4, 5, 6, 8 дугаар сургууль/
- Номын сангийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/
- Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/
- Хот тохижилтын парк шинэчлэл /Баян-Өлгий, Өлгий сум/ зэрэг төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

Төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах улсын комисс нь барилга байгууламжийн болон тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээнд өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хуудсыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу хөтөлж, үүрэг даалгаврын биелэлтийг тооцож ажилласан байна. Энэхүү үүрэг даалгаврын биелэлтийн үндэслэн ашиглалтад хүлээн авах актыг үйлдсэн байна.

Б.5.2. Зарим төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээг дүгнэж, гэрээний үүргийн биелэлтийг тооцож ажилласан байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 43 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт хэлтсээс төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг үндэслэж, гэрээ дүгнэх маягтаар дүгнэж, ажлын баримтад хавсаргасан байна.

Хүснэгт №5

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээг дүгнэсэн эсэх	Үүргийн биелэлтийг тооцож ажилласан эсэх
А	1	2	3

1	Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/	Тийм	Тийм
2	Сумын төвийн гэрэлтүүлэг /Баян-Өлгий, Ногооннуур сум/	Тийм	Тийм
3	Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/	Тийм	Тийм
4	Аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвийн компьютер, тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/	Тийм	Тийм
5	Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум, 1, 2, 3, 4, 5, 6, 8 дугаар сургууль/	Тийм	Тийм
6	Номын сангийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/	Тийм	Тийм
7	Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/	Тийм	Тийм
8	Хот тохижилтын парк шинэчлэл /Баян-Өлгий, Өлгий сум/	Тийм	Тийм
НИЙТ ДҮН			

Эх сурвалж: Аудитын судалгаа

Б.5.3. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 8 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгасан эсэх, хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг шалгаж үзэхэд нийт 2,263.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 7 төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагууд хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

Өлгий сумын 1 дүгээр багт 173.2 сая төгрөгөөр хэрэгжсэн цэвэр усны шугам татах ажлыг ашиглагч байгууллага орон нутгийн өмчийн “Суат” ХХК нь орлогод аваагүй байсан байна. Аудитын дүнгээр энэхүү төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг орлогод авч, бүртгэлд тусгах талаар албан шаардлага өгөгдлөө.

Хүснэгт №6

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний				Хэрэгжиж дууссан		Ажлын гүйцэтгэл
		Байгуулсан		Ажил гүйцэтгэх хугацаа		Байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын		
		Огноо	Үнийн дүн	Эхлэх огноо	Дуусах огноо	Актын дугаар	Актын огноо	
A	1	2	3	4	5	6	7	
1	Аймаг, сумын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/	2022/04/06	47.8	2022/04/11	2022/06/16	№12	2022.05.05	100%
2	Сумын төвийн гэрэлтүүлэг /Баян-Өлгий, Ногооннуур сум/	2022/01/04	31.9	2022/05/02	2022/08/31	№30/22	2022/08/24	100%
3	Цэвэр усны шугам татах /Баян-Өлгий, Өлгий сум, 1 дүгээр баг, 1, 2 дугаар гудамж/	2022/04/22	173.2	2022/05/25	2022/08/30	№БЗА109/22	2022/12/13	100%
4	Аймгийн төвийн өрхийн эрүүл мэндийн төвийн компьютер, тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/	2022/01/20	20.0	2022/01/15	2022/12/30	№17	2022/11/16	100%
5	Сургуулийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум, 1, 2, 3, 4, 5, 6, 8 дугаар сургууль/	2022/04/28	149.4	2022/04/28	2022/05/28	№А/417	2022/06/17	100%
6	Номын сангийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/	2022/03/24	38.8	2022.03.24	2022.07.24	№15	2022/05/05	100%

7	Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/	2021/06/22	285.7	2021/0701	2022/11/01	№12/2022	2022/10/26	100%
8	Хот тохижилтын парк шинэчлэл /Баян-Өлгий, Өлгий сум/	2021/06/31	1690.2	2021/07/02	2022/07/04	№5,6,15,18,19,20,35,36	2022/01/24, 2022/04/27, 2022/09/16, 2022/11/09.	100%
НИЙТ ДҮН			2437,0					

ЭХ сурвалж: Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний судалгаа

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж, ашиглалтад хүлээн авсан дээрх 8 төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагууд зориулалтын дагуу ашиглаж ирсэн байна.

В.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

В.1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 18 төсөл арга хэмжээ нь дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна

Баян-Өлгий аймгийн ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит VIII дугаар хуралдааны 93 дугаар тогтоолын хавсралтаар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 18 их засварын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төлөвлөсөн 18 их засварын төсөл арга хэмжээний 14-ийг боловсролын салбарт, 4-ийг бусад салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 18 төсөл арга хэмжээнүүд нь урт болон богино хугацааны хөгжлийн бичиг баримттай уялдсан эсэхийг шалгаж үзэхэд:

- Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн 3.5, 8.1 дэх заалттай нийцсэн байна.
- Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1.10-т “Сургууль, цэцэрлэгт сурч боловсрох ээлтэй орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх ..”, 3.2.1-т “Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор иргэдийг нийтийн биеийн тамираар хичээллэхэд дэмжлэг үзүүлж, олон нийтийн ажил үйлчилгээг нэмэгдүүлнэ”, 8.1.1-д “Аймгийн төв болон сумдын хөгжлийг дэмжиж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг сайжруулан, амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн заалтуудад нийцсэн байна.
- Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Хөгжилд тэмүүлсэн Баян-Өлгий” үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.2-т “Аймгийн төв болон сумдын хөгжлийг дэмжиж, иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулан, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, 6.2.3.2-т “Сумдын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөл, урсгал засвар хийх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ”, 6.2.4.2-т “Сумдын Соёлын төвийн барилгыг шинээр барих, урсгал засвар хийх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ” гэсэн заалтуудтай нийцсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 18 төсөл арга хэмжээнүүд нь дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

В.1.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн төлөвлөсөн байна

Аймгийн ИТХ-ын 2022 оны 93 дугаар тогтоолын хавсралтаар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 18 төсөл арга хэмжээний төсөвт өртгийг 1050.0 сая төгрөгөөр төлөвлөж, тайлант онд санхүүжих дүнг 900.8 сая төгрөгөөр баталсан байна.

Үүнээс: 15 төсөл арга хэмжээг тайлант онд хэрэгжүүлэхээр, 3 төсөл арга хэмжээг он дамжин 2022-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг шалгаж үзэхэд:

- 18 төсөл арга хэмжээг боловсролын болон бусад салбарт ашиглагдаж буй барилга байгууламжийн ашиглах хугацааг уртасгах, сайжруулах зорилгоор их засварт төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.1, 28.3.2, 28.3.3 дахь заалттай нийцсэн байна.
- 18 төсөл арга хэмжээний ажлын төсөв, зураг нь батлагдсан нь Төсвийн тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.4 дэх заалттай нийцсэн байна.
- 18 төсөл арга хэмжээ нь Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолын 3.1.4.1, 3.1.4.2, 3.1.4.3, 3.1.4.5, 3.1.4.6, 3.2.1 дэх заалтуудад нийцсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг шалгаж үзэхэд:

- Төлөвлөсөн 18 төсөл арга хэмжээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.1, 13.3.2, 13.3.3 дахь заалтыг зөрчөөгүй байна.

Дээрх байдлаас дүгнэлт хийж үзэхэд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн төлөвлөсөн байна.

В.2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮНТЭЙ БАЙНА

В.2.1. Худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгохдоо 8 төсөл арга хэмжээг шууд худалдан авах аргаар, 7 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 3 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 18 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2022 оны 6 дугаар сарын 20-ноос 12 дугаар сарын 14-ны хооронд зохион байгуулсан байна.

Төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан өдрөөр тооцож үзэхэд 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 7 төсөл арга хэмжээ 79-100 хоногоор, 9 төсөл арга хэмжээ 101-200 хүртэл хоногоор, 2 төсөл арга хэмжээ 201-227 хоногоор тус тус хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д “батлагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт № 7

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг явуулах хуулийн хугацаа	Гэрээ байгуулсан онгоо	Хугацаа хэтэрсэн хоног
1	Буянт сумын Соёлын төвийн их засварын ажил	2022/05/01	2022/07/29	89
2	Алтай сумын Соёлын төвийн их засварын ажил	2022/05/01	2022/08/30	121
3	Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны /75 А/ корпусын их засварын ажил	2022/05/01	2022/09/20	142
4	Булган сумын 1 дүгээр сургуулийн хөвгүүдийн дотуур байр их засварын ажил	2022/05/01	2022/07/28	88
5	Булган сумын 1 дүгээр сургуулийн охидын дотуур байр их засварын ажил	2022/05/01	2022/07/28	88
6	Ногооннуур сумын 1 дүгээр цэцэрлэгийн /2 танхим/ их засварын ажил	2022/05/01	2022/07/28	88
7	Алтанцөгц сумын хуучин эрүүл мэндийн төвийн барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай болгож засварлах ажил	2022/05/01	2022/08/15	106
8	Ногооннуур сумын сургуулийн биеийн тамирын заалны их засварын ажил	2022/05/01	2022/09/19	141
9	Хурманханы нэрэмжит Хөгжимт драмын театрын засварын ажил	2022/05/01	2022/07/19	79
10	Спорт цогцолборын доторх индрийн засварын ажил	2022/05/01	2022/08/31	122
11	Баяннуур сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засварын ажил	2022/05/01	2022/07/21	81
12	Толбо сумын ЕБС-ийн спорт заалны засварын ажил	2022/05/01	2022/08/18	109
13	МСҮТ-ийн сургуулийн гадна талын засварын ажил	2022/05/01	2022/07/20	80
14	Номын сангийн хаалга, цонхны засварын ажил	2022/05/01	2022/08/16	107
15	Бугат сумын ЕБС-ийн их дотуур байрны их засварын ажил	2022/05/01	2022/08/24	115
16	Улаанхус сумын ЕБС-ийн 1 дүгээр сургуулийн их засварын ажил	2022/05/01	2022/08/29	120
17	Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны /75 Б/ корпусын их засварын ажил	2022/05/01	2022/12/07	220
18	Цэнгэл сумын Загаст нуурын багийн дотуур байрны барилгыг сургуулийн зориулалттай болгож их засварлах ажлыг	2022/05/01	2022/12/14	227
Хэтэрсэн дундаж хоног 118				2123

Эх сурвалж: Ажил гүйцэтгэх гэрээ, судалгаа.

Тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах явцад 2 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтад гомдол гарч, гэрээг 2022 оны 12 дугаар сарын 07, 14-ны өдөр байгуулсан байна.

Аудитын дүнгээр худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөгдлөө.

Аймгийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороог Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-д заасны дагуу АЗ сертификаттай, худалдан авах ажиллагааны салбарын мэргэжилтнүүд, аймгийн ЗДТГ-ын ажилтнуудын төлөөлөл, иргэний төлөөллийг оролцуулан 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсан байна.

Үнэлгээний хороо нь тендерийн бичиг баримтыг зохих журмын дагуу боловсруулж, тендер шалгаруулалтыг явуулсан байна.

В.2.2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 88.9 хувь нь хугацаандаа хэрэгжсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 18 төсөл арга хэмжээний 15 төсөл арга хэмжээг нь 2022 онд хэрэгжүүлэхээр, 3 төсөл арга хэмжээг он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Шууд гэрээ байгуулсан 8, харьцуулалтын аргаар хэрэгжүүлсэн 7, нийт 15 төсөл, арга хэмжээ нь гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжиж, ашиглалтад хүлээн авсан байна.

Гүйцэтгэгчийг нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулсан 3 төсөл арга хэмжээний 1 төсөл арга хэмжээ нь 76.7 хувийн гүйцэтгэлтэй, 2 төсөл арга хэмжээ нь гэрээг хугацаа хожимдож хийсний улмаас хэрэгжээгүй байна.

Улаанхус сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын ажил нь он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээ бөгөөд гэрээнд заасан ажлыг бүрэн хийж, 76.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны \75 Б\ корпусын засварын ажлыг 133.9 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын гэрээг 2022 оны 12 дугаар сарын 07-нд, Цэнгэл сумын Загаст нуур багийн дотуур байрны барилгыг сургуулийн зориулалттай болгож засварлах ажлыг 150.0 сая төгрөгөөр гүйцэтгэх ажлын гэрээг 2022 оны 12 дугаар сарын 14-нд байгуулснаас шалтгаалан тайлант онд хэрэгжээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.4-д “төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүсэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байх тул зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөгдлөө.

В.2.3 Төсөл арга хэмжээний санхүүжилтийг хууль, журам, гэрээнд нийцүүлэн олгосон байна

Аймгийн ИТХ-ын 2022 оны 93 дугаар тогтоолын хавсралтаар Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын шинээр хэрэгжих 18 төсөл арга хэмжээний 2022 онд санхүүжих дүнг 900.8 сая төгрөгөөр баталсан байна. Үүнээс 15 төсөл арга хэмжээ нь тайлант онд бүрэн хэрэгжиж, он дамжин хэрэгжих 1 төсөл арга хэмжээ нь 76.7 хувийн гүйцэтгэлтэй, 2 төсөл арга хэмжээ нь хэрэгжээгүй байна.

Гүйцэтгэлээр нийтдээ 684.1 сая төгрөгийн санхүүжилт олгосноос бүрэн хэрэгжиж дууссан 15 төсөл арга хэмжээнд 454.1 сая төгрөгийн, он дамжин хэрэгжих 1 төсөл арга хэмжээнд 230.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Бүрэн хэрэгжсэн 15 төсөл арга хэмжээнд гэрээний дагуу 454.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Хүснэгт №8		/ мянган төгрөгөөр/					
д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Ажил эхэлснээс хойш олгосон нийт санхүүжилт	2022 онд олгосон санхүүжилт	Ажлын бодит гүйцэтгэл		
1	Буянт сумын Соёлын төвийн их засварын ажил	38,200.00	37,500.70	37,500.70	37,500.70	38,200.00	100%
2	Алтай сумын Соёлын төвийн их засварын ажил	24,900.00	24,474.90	24,474.90	24,474.90	24,900.00	100%
3	Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны /75 А/ корпусын их засварын ажил	37,600.00	12,518.70	12,518.70	12,518.70	37,600.00	100%
4	Булган сумын 1 дүгээр сургуулийн хөвгүүдийн дотуур байр их засварын ажил	20,000.00	20,000.00	20,000.00	20,000.00	20,000.00	100%
5	Булган сумын 1 дүгээр сургуулийн охидын дотуур байр их засварын ажил	20,000.00	20,000.00	20,000.00	20,000.00	20,000.00	100%
6	Ногооннуур сумын 1 дүгээр цэцэрлэгийн /2 танхим/ их засварын ажил	20,000.00	19,652.70	19,652.70	19,652.70	20,000.00	100%
7	Алтанцөгц сумын хуучин эрүүл мэндийн төвийн барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай болгож засварлах ажил	95,000.00	31,781.90	31,781.90	31,781.90	95,000.00	100%
8	Ногооннуур сумын сургуулийн биеийн тамирын заалны их засварын ажил	29,600.00	8,865.00	8,865.00	8,865.00	29,600.00	100%
9	Хурманханы нэрэмжит Хөгжимт драмын театрын засварын ажил	15,000.00	14,740.70	14,740.70	14,740.70	15,000.00	100%
10	Спорт цогцолборын доторх индрийн засварын ажил	15,000.00	14,603.10	14,603.10	14,603.10	15,000.00	100%
11	Баяннуур сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засварын ажил	20,000.00	19,018.00	19,018.00	19,018.00	20,000.00	100%
12	Толбо сумын ЕБС-ийн спорт заалны засварын ажил	20,000.00	19,115.90	19,115.90	19,115.90	20,000.00	100%
13	МСҮТ-ийн сургуулийн гадна талын засварын ажил	20,000.00	19,131.80	19,131.80	19,131.80	20,000.00	100%
14	Номын сангийн хаалга, цонхны засварын ажил	39,300.00	38,268.40	38,268.40	38,268.40	39,300.00	100%
15	Бугат сумын ЕБС-ийн их дотуур байрны их засварын ажил	39,500.00	38,796.90	38,796.90	38,796.90	39,500.00	100%
16	Улаанхус сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын ажил	230,000.00	222,061.20	222,061.20	222,061.20	230,000.00	76.6%
Бүгд дүн		684,100.0	560,529.9	560,529.9	560,529.9	684,100.0	

Эх сурвалж: Ажлын баримт, дансны хуулга

Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг буруу зөрүү олгосон зөрчил дутагдал илрээгүй.

В.2.4. Хэрэгжсэн 2 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавиагүй байна

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Барилга, захиалагчийн албатай 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр гэрээ байгуулж, Аймгийн Засаг даргаар батлуулж, улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийт 28 төсөл, арга хэмжээнд техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна. Үүнд:

Төсөл арга хэмжээний ажлуудад барилгын норм ба дүрэм, зураг төсөв, технологийн дагуу хийж гүйцэтгэж байгаа эсэхэд өдөр тутмын хяналт тавьж, зарим нэг шаардлага хангаагүй ажлуудыг гүйцэтгэгчийн зардлаар дахин хийлгүүлж ажилласан байна.

Барилга, захиалагчийн албанаас ирүүлсэн 2022 оны үйл ажиллагааны тайлангаас үзэхэд орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжсэн 649.1 сая төгрөгийн өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, 35.0 сая төгрөгийн өртөгтэй 2 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавиагүй байна. Үүнд:

Ногооннуур сумын 1 дүгээр цэцэрлэгийн /2 танхим/ 20.0 сая төгрөгийн их засварын ажил, Аймгийн Хөгжимт драмын театрын 15.0 сая төгрөгийн засварын ажилд хяналт тавьсан эсэх нь тодорхойгүй байна. Үүнээс үзэхэд Барилга, захиалагчийн албанаас төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг дутуу хэрэгжүүлсэн байна гэж үзлээ.

В.2.5. Төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 16 төсөл арга хэмжээний 15 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлээр хүлээн авч ашиглалтад оруулсан байна

Хэрэгжиж дууссан 15 төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Хүснэгт №9

	Төсөл, арга хэмжээний нэр	Байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын	
		Актын дугаар	Актын огноо
1	Буянт сумын Соёлын төвийн их засварын ажил	24/22	2022/08/12
2	Алтай сумын Соёлын төвийн их засварын ажил	84/22	2022/10/24
3	Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны /75 А/ корпусын их засварын ажил		
4	Булган сумын 1 дүгээр сургуулийн хөвгүүдийн дотуур байр их засварын ажил	95/22	2022/11/16
5	Булган сумын 1 дүгээр сургуулийн охидын дотуур байр их засварын ажил	96/22	2022/11/16
6	Ногооннуур сумын 1 дүгээр цэцэрлэгийн /2 танхим/ их засварын ажил	88/22	2022/10/28
7	Алтанцөгц сумын хуучин эрүүл мэндийн төвийн барилгыг хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай болгож засварлах ажил	118/22	2022/12/23

8	Ногооннуур сумын сургуулийн биеийн тамирын заалны их засварын ажил	116/22	2022/12/2
9	Хурманханы нэрэмжит Хөгжимт драмын театрын засварын ажил	64/22	2022/09/26
10	Спорт цогцолборын доторх индэрийн засварын ажил	83/22	2022/10/24
11	Баяннуур сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засварын ажил	40/22	2022/09/06
12	Толбо сумын ЕБС-ийн спорт заалны засварын ажил	57/22	2022/09/22
13	МСҮТ-ийн сургуулийн гадна талын засварын ажил	81/22	2022/10/20
14	Номын сангийн хаалга, цонхны засварын ажил	65/22	2022/09/26
15	Бугат сумын ЕБС-ийн их дотуур байрны их засварын ажил	82/22	2022/10/20

Эх сурвалж: Байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт

Аудитын дүнгээр Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Алтанцөгц сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг Хүүхдийн цэцэрлэгийн зориулалттай болгож засварлах 95.0 сая төгрөгийн, Спорт цогцолборын доторх индэрийн 15.0 сая төгрөгийн, Толбо сумын Ерөнхий боловсролын сургуулийн спорт заалны 20.0 сая төгрөгийн, Аймгийн Номын сангийн хаалга, цонхны 40.0 сая төгрөгийн засварын ажил нийтдээ 170.0 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан боловч ашиглагч байгууллагуудад орлого авахуулж, данс бүртгэлд тусгуулаагүй, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа Улаанхус сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засварын ажлын 230.0 сая төгрөгийн дусаагүй барилгыг орлого авч данс бүртгэлд тусгаагүй байсан зөрчлийг арилгах талаар албан шаардлага өгөгдсөн.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 95 хувь нь “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-той нийцсэн байна.
2. Батлагдсан төсөл арга хэмжээ нь Монгол Улсын 2021-2025, аймгийн 2021-2025 оны үндсэн чиглэлд нийцсэн боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл хөтөлбөрийн 63.6 хувь нь тусгагдаагүй байна
3. Аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслээгүй 10 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнд оруулж баталсан байна.
4. Батлагдсан төсөл арга хэмжээний 38.8 хувийн зураг төсөв нь төлөвлөлтийн шатанд бэлэн болоогүй байна
5. Тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна
6. Барилга байгууламжийг холбогдох норм дүрэм, стандарт, батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэсэн байна
7. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна
8. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагаас хяналтыг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлж ажилласан байна
9. Төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах комисс нь холбогдох хууль, дүрмийн дагуу дүгнэлт гаргаж хүлээн авсан байна
10. Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага бүртгэлд бүрэн тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна
11. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний 88.9 хувь нь хугацаандаа хэрэгжсэн байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Мухамед-т:

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлтийн шатны явцтай холбоотой баримт материалыг архивын стандартын дагуу баримтжуулж хадгалах.

Зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-3264

2023.04.21 № 5-03/413

танай _____ -ны № _____ - т


**АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Танай байгууллагаас 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн аудитын тайлантай танилцав.

Тухайн аудит нь холбогдох хууль, журмын дагуу хийгдсэн гэж үзэж байна. Тайлантай холбоотой ямар нэгэн саналгүй болно.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ФЕСТИВАЛЬ



0108230983



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/08

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч /Х.Арман/-д зөвлөсүгэй.

4. Аудитын дүнгээр өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор /М.Айнур/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.



М.ХУАНГАН

D:\bichig hereg\2023\tushaal.doc